


НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариуг сонгоорой.

1. Монгол орны зүүн захын цэг аль нь вэ? /1 оноо/
 А. Монгол Шарын даваа В. Өвөрхөшөөтийн булаг С. Орвог Гашууны Бор толгой
 D. Таван Богдын Мааньт уул E. Соёлз уулын Модтой Хамар даваа

2. Масштабыг бичиглэх хэлбэрээр нь ангилсан бүдүүвчийг гүйцээж нөхөөрэй. /1 оноо/



- A. Босоо масштаб
- B. Үсгэн масштаб
- C. Тойргон масштаб
- D. Нэрлэсэн масштаб
- E. Ташуу масштаб

3. Ямаан сүргийн тоо толгойгоор тэргүүлэгч аймаг аль нь вэ? /1 оноо/
 А. Дорнод В. Дорноговь С. Сэлэнгэ D. Орхон E. Баянхонгор

4. Монгол орны агаарын үнэмлэхүй бага температур хаана бүртгэгдсэн бэ? /1 оноо/
 А. Дэлгэрмөрөн В. Зүүнговь С. Хэрлэн Баян-Улаан D. Хархорин E. Галуут

5. Матрын зам нь өргөргийн хэдэн градус вэ? /1 оноо/
 А. х.ө 23,5° В. ө.ө 23,5° С. х.ө 45° D. ө.ө 66,5° E. х.ө 90°

6. Дэлхийгээс нар хүртэлх зайг сонгоно уу. /1 оноо/
 А. 228 сая км В. 365 сая км С. 108 сая км D. 150 сая км E. 58 сая км

7. Дараах таних тэмдэг газарзүйн зурагт юуг илэрхийлэх вэ? /1 оноо/



- A. Шилмүүст ой
- B. Худаг
- C. Өндөр хүчдэлийн шон
- D. Тариан талбай
- E. Уул

8. Дэлхийн гадаргын хэдэн хувийг далай эзэлдэг вэ? /1 оноо/
 А. 92% В. 50% С. 10% D. 25% E. 71%

9. Хамгийн том хуурай газрыг сонгоно уу. /1 оноо/
 А. Африк В. Хойд Америк С. Еврази D. Антарктид E. Австрали


10. Дөргөний усан цахилгаан станц аль аймагт байдаг вэ? /1 оноо/
 А. Дундговь В. Ховд С. Өвөрхангай D. Дорнод E. Төв

11. Буриад ястны олонх нь амьдардаг аймаг аль нь вэ? /1 оноо/
 А. Говь-Алтай В. Дорноговь С. Дорнод D. Өвөрхангай E. Баянхонгор



12. Ховд хот нь аль эдийн засгийн бүс нутгийн тулгуур төв вэ?

/1 оноо/



- A. Баруун
- B. Хангайн
- C. Улаанбаатарын
- D. Зүүн
- E. Төвийн

13. Наранд хамгийн ойрхон гараг аль нь вэ?

/1 оноо/

- A. Тэнгэрийн ван
- B. Ангараг
- C. Санчир
- D. Буд
- E. Дэлхий

14. Дэлхийн хамгийн том мөсөөр бүрхэгдсэн арал аль нь вэ?

/1 оноо/

- A. Сахалин
- B. Шинэ Зеланд
- C. Борне
- D. Хавай
- E. Гренланд

15. Хотын захаар хүний хамгийн наад захын амьдралын ая тух, эрүүл ахуйн шаардлага хангаагүй суурин бий болох үзэгдлийг юу гэж нэрлэдэг вэ?

/1 оноо/

- A. Хуурамч хотжилт
- B. Дагуул хот
- C. Бүлэг тосгон
- D. Хотын тэсрэлт
- E. Агломераци

16. Хэнтий нурууны ноён оргилыг сонгоно уу.

/1 оноо/

- A. Хэрлэн тоонот
- B. Богдхан
- C. Асралт хайрхан
- D. Өндөрхаан
- E. Зоргол хайрхан

17. Хээрийн бүсийн амьтныг сонгоно уу.

/1 оноо/



- A. Хавтгай
- B. Хэрэм
- C. Цаа буга
- D. Цагаан зээр
- E. Жирх

18. Монгол Алтай нуруунаас эх авч Хар-Ус нуурт цутгадаг, Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамаарагдах гол аль нь вэ?

/1 оноо/

- A. Ховд
- B. Чулуут
- C. Орхон
- D. Халх
- E. Хэрлэн

19. Төмөрлөг бус ашигт малтмалыг сонгоорой.

/1 оноо/

- A. Төмөр
- B. Хайлуур жонш
- C. Нүүрс
- D. Цайр
- E. Газрын тос

20. Жилд 30000 тонн үр тариа боловсруулж гурил, хүүхдийн будаа зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үндэсний хүнс үйлдвэрлэгч компанийг олно уу.

/1 оноо/

- A. Алтан тариа
- B. Сүү
- C. Эрдэнэт хивс
- D. Мах импекс
- E. АПУ

21. 12-р сарын 22-нд нар хаана эгц тусах вэ?

/1 оноо/

- A. Хойд туйлын цагариг
- B. Мэлхийн зам
- C. Экватор
- D. Матрын зам
- E. Өмнөд туйл



22. Буурай хөгжилтэй орон аль нь вэ? /1 оноо/

- A. Тайвань В. Швед С. Израйл D. Канад E. Либер

23. Хүний үйл ажиллагаатай холбоотой цөлжилт үүсгэж буй хүчин зүйлийг сонгоно уу. /1 оноо/

- A. Чулуулгийн эвдрэл В. Удаан хугацааны ган
C. Бэлчээр талхлалт D. Шороон шуурга E. Хөрсний гулсалт

24. БНХАУ, Лаос, Камбож, Вьетнам улсуудын нутгаар дамжин урсдаг мөрөнг сонгоно уу. /1 оноо/

- A. Меконг В. Инд С. Амар D. Брахмапутра E. Обь

25. Айраг өртөөнөөс салаа төмөр замаар аль сууринд очих боломжтой вэ? /2 оноо/



- A. Шарын гол
B. Салхит
C. Мардай
D. Багануур
E. Бор-Өндөр

26. Кени улсын хойд хэсэгт 3,5 сая хүн өлсгөлөнгийн улмаас амь насаа алдахад хүргэсэн байгалийн хүчин зүйлийг сонгоорой. /2 оноо/

- A. Малын тоо багасах В. Удаан үргэлжилсэн ган С. Үер
D. Салхины эрози E. Уул уурхай

27. Дараах улс орнуудын нутаг дэвсгэрийн газарзүйн зургийг ажиглаад аль нь ОХУ улс болохыг тодорхойлно уу. /2 оноо/



28. Цагаан бөлбөө цэцэг, хотон, гургуул, зэгсний гахай, бөхөнгийн гол байршил нутгийг хамгаалах үндэслэлээр 1997 онд улсын тусгай хамгаалалтад авсан газрыг сонгоно уу. /2 оноо/

- A. Сүйхэнт ДГ В. Хүйсийн Найман нуур ДГ С. Их Газарын чулуу БНГ
D. Тосон-Хулстай БНГ E. Хар-Ус нуур БЦГ

29. Та Хойд Европын тундрын бүсэд аялахдаа доорх уугуул иргэдийн алиных нь соёл, зан заншил, ахуй амьдралтай танилцаж судалгаа хийх вэ? /2 оноо/

- A. Бушмен В. Индиан С. Эксимос D. Сами E. Аброген

30. Газарзүйн зурагт тэмдэглэсэн А цэгийн байршил дээрх газрын нэрийг олоорой. /2 оноо/



- A. Намибын цөл
B. Камерун галт уул
C. Викторын хүрхрээ
D. Конго мөрөн
E. Аконкагуа оргил

31. Зургийг ажиглаад билгийн тооллын хэдний сар болохыг тодорхойлоорой. **/2 оноо/**



- A. Битүүн
- B. Шинийн арван таван
- C. Хуучдын арван есөн
- D. Шинийн гурван
- E. Хуучдын хорин найман

32. Болор, хээрийн жонш, гялтгануурын нэгдлээс бүрэлдэн тогтсон шургамал магмын чулуулгийг сонгоно уу. **/2 оноо/**

- A. Боржин
- B. Хөрзөн чулуу
- C. Гантиг
- D. Элсэн чулуу
- E. Газрын тос

33. Байгалийн төрх байдлыг голлон ургадаг ургамалтай нь зөв тохируулаарай. **/2 оноо/**

1	Говь	a	Гацуур
2	Тайга	b	Заг
3	Хээр	c	Арц
4	Таг	d	Ерхөг

- A. 1-d, 2-c, 3-b, 4-a
- B. 1-b, 2-a, 3-d, 4-c
- C. 1-c, 2-a, 3-d, 4-b
- D. 1-b, 2-a, 3-c, 4-d
- E. 1-b, 2-c, 3-d, 4-a

34. “Google earth” программаас авсан зургийг ажиглаад аль нуур болохыг олоорой. **/2 оноо/**



- A. Увс нуур
- B. Хөвсгөл нуур
- C. Хяргас нуур
- D. Хар-Ус нуур
- E. Орог нуур

35. 10°С температуртай агаарын үнэмлэхүй чийг 3,11гр/м³ байсан бол харьцангуй чийгийн хэмжээг олоорой. (үнэмлэхүй чийгийн багтаамж 9,41гр/м³) **/2 оноо/**

- A. 33%
- B. 10%
- C. 55%
- D. 79%
- E. 29%

36. Дорноговь аймгийн Мандах суманд оршдог 10,64 сая тонн зэс, молибдений судлагдсан нөөцтэй стратегийн орд газрыг сонгоно уу. **/2 оноо/**

- A. Адуунчулуун
- B. Цагаан Суварга
- C. Бороо
- D. Бүрэнхаан
- E. Нарийн Сухайт

37. Улс орнуудыг засаглалын хэлбэртэй нь харгалзуулна уу. **/2 оноо/**

1. Катар	a. Үндсэн хуульт хаант засаглал
2. Польш	b. Парламентийн БН засаглал
3. Дани	c. Ерөнхийлөгчийн БН засаглал
4. ОХУ	d. Хэмжээгүй эрхт хаант засаглал

- A. 1-b, 2-c, 3-a, 4-d
- B. 1-a, 2-b, 3-c, 4-d
- C. 1-d, 2-a, 3-b, 4-c
- D. 1-d, 2-b, 3-a, 4-c
- E. 1-c, 2-d, 3-a, 4-b


38. 1947 онд байгуулагдсан. Төв нь Швейцарын Женев хотод байрладаг. Бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэл үйлчилгээг өргөтгөх, гаалийн татварыг бууруулах, худалдааны саад тотгорыг арилгах, харилцан ашигтай тэгш эрхтэй гэрээ хэлэлцээр байгуулах, ажлын байр бодит орлогыг нэмэгдүүлэх, ард түмний амьдралыг дээшлүүлэх зорилготой олон улсын байгууллага аль нь вэ? **/2 оноо/**

- A. Дэлхийн аялал жуулчлалын байгууллага
- B. Европын холбоо
- C. Дэлхийн банк
- D. Умард Атлантын гэрээ
- E. Дэлхийн худалдааны байгууллага



39. Хотгор гүдгэрийн хэлбэрийг хаяалбар шугамаар зөв дүрсэлсэнтэй нь харгалзуулна уу.


/2 оноо/



- A. 1-с, 2-а, 3-б, 4-д
- B. 1-д, 2-а, 3-б, 4-с
- C. 1-а, 2-б, 3-с, 4-д
- D. 1-б, 2-с, 3-д, 4-а
- E. 1-д, 2-а, 3-с, 4-б

40. Хот байгуулалтын олон цөмт хэлбэрийг дүрсэлсэн зурагт 3 дугаараар ямар хорооллын байршлыг харуулсан байна вэ?

/2 оноо/



- A. Орлого багатай иргэдийн орон сууцны хороолол
- B. Бөөний худалдаа, хөнгөн үйлдвэрийн дүүрэг
- C. Аж үйлдвэрийн бүс
- D. Төвийн бизнес дүүрэг
- E. Хүнд аж үйлдвэрийн бүс


41. Их даралтын муж зонхилдог, дэлхийн томоохон цөлүүд үүссэн газарзүйн бүслүүр аль нь вэ?

/2 оноо/

- A. Туйлын бүслүүр
- B. Сэрүүн бүслүүр
- C. Халуун бүслүүр
- D. Экваторын бүслүүр
- E. Хүйтэвтэр бүслүүр

42. Дэлхийн худалдааны газарзүйн зурагт ямар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ болон экспорт, импортын чиглэлийг дүрслэн харуулсан байна вэ?


/2 оноо/



- A. Газрын тос
- B. Чихрийн манжин, нишингэ
- C. Нүүрс
- D. Цагаан будаа
- E. Байгалийн хий

43. Дараах график нь аль хотын уур амьсгалыг илэрхийлж байна вэ?

/2 оноо/



- A. БНХАУ, Бээжин
- B. Канад, Оттава
- C. Австрали, Сидней
- D. ОХУ, Верхоянск
- E. Грек, Афин



44. Дундаж зузаан нь 2900 км, 4-5 гр/см³ нягттай, чичирхийллийн долгионы хурд 8-14 км/сек, төмөр, магни, цахиурын ислүүд ихтэй, дээд болон доод гэсэн хоёр үелэлд хуваагддаг давхаргыг олно уу. **/2 оноо/**


- A. Гадаад цөм B. Астеносфер C. Газрын давхарга D. Манти E. Дотоод цөм

45. Газарзүйн зурагт тодоор дүрслэгдсэн улс, бүс нутгийг зөв тодорхойлно уу. **/2 оноо/**



- A. Румын, Зүүн Европ
B. Герман, Баруун Европ
C. Польш, Баруун Европ
D. Испани, Өмнөд Европ
E. Украин, Зүүн Европ

46. Монгол улсын Бичигт боомтоор аль улсын боомт хот руу шууд гарах вэ? **/2 оноо/**



- A. БНХАУ-ын Сэхээ
B. БНХАУ-ын Эрээн
C. ОХУ-ын Хандгайт
D. ОХУ-ын Монд
E. БНХАУ-ын Зүүн Хатавч

47. БНХАУ-ын засаг захиргааны газарзүйн зураг дээрх тодоор дүрслэгдсэн мужийн нэрийг олно уу. **/2 оноо/**



- A. Ганьсү муж
B. Төвдийн Өөртөө Засах Орон
C. Өвөр Монголын Өөртөө Засах Орон
D. Шинжаан-Уйгурын Өөртөө Засах Орон
E. Хөхнуур муж

48. Дэлхийн улс төр, эдийн засгийн харилцаанд голлох байр суурь эзэлдэг, төмөрлөг боловсруулах болон цахилгаан техникийн үндэстэн дамнасан корпорациуд, дэлхийн хамгийн том атомын цахилгаан станцтай, хүнд даацын, суудлын авто машин, робот үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч улс аль нь вэ? **/2 оноо/**

- A. Саудын Араб B. Шинэ Зеланд C. Япон D. Испани E. Мексик

49. Аймгуудыг төвтэй нь тохируулаарай. **/2 оноо/**

1	Өмнөговь	a	Сүхбаатар
2	Өвөрхангай	b	Чойр
3	Говь-Сүмбэр	c	Арвайхээр
4	Сэлэнгэ	d	Даланзадгад

- A. 1-a, 2-b, 3-d, 4-c
B. 1-d, 2-c, 3-b, 4-a
C. 1-b, 2-a, 3-d, 4-c
D. 1-d, 2-b, 3-c, 4-a
E. 1-c, 2-b, 3-d, 4-a

50. Бэлчээрийн ургац 315 кг/га, нэг хонины хоногт идэх өвс 2,1 кг/га, бэлчээр ашиглах хугацаа 30 хоног бол хээрийн бүсийн бэлчээрийн даацыг нэгж талбайд идээшлэх малын тоогоор тооцоолоорой. **/2 оноо/**

- A. 5 хонь B. 13 хонь C. 4 хонь D. 14 хонь E. 63 хонь



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:


1. Хариултын хуудасны санамж 2-р хэсгийг анхааралтай уншиж танилцаарай.
2. Даалгаврын хариуг даалгавар тус бүр дэх зааврын дагуу гүйцэтгэнэ үү.

2.1. ЗУ 45°-д орших Сана хотод Бямба гарагийн 08 цаг болж байхад БУ 150°-д орших Анкориж хотод ямар гарагийн хэдэн цаг болж байх вэ? **/6 оноо/**

Алхам

- гариг [a] [Даваа бол 1, Мягмар бол 2, Лхагва бол 3, Пүрэв бол 4, Баасан бол 5, Бямба бол 6, Ням бол 7 цифрээр төлөөлүүлэн тэмдэглээрэй] /2 оноо/
- цаг [bc] /4 оноо/

2.2. Сайншанд хотод цаг агаарын мэдээгээр агаарын даралт 767 гПа гэж зарласан бол В хотоос дээш хэдэн метр өндөрт оршиж байна вэ? (В хотод агаарын даралт 860 гПа)



Алхам


/6 оноо/

- агаарын даралтын зөрүү [ab], /2 оноо/
- хотын орших өндөр [cde] /4 оноо/



2.3. Өгөгдсөн дүрсийг ашиглан нуурын талбайг ойролцоогоор олж, км²-аар илэрхийлнэ үү.
Зургийн масштаб 1:300000.

/6 оноо/



Алхам

-гурвалжингийн талбай [a] см², /2 оноо/

-тэгш өнцөгтийн талбай [bc] см², /2 оноо/

-масштаб ашиглаж олсон нуурын талбай [def] км²
/2 оноо/

2.4. Дараах улсуудыг хүн амын олонх нь шүтдэг шашины урсгалтай нь зөв харьцуулаарай.

/6 оноо/

Улс орнууд		Шашины урсгалууд	
a.	Казахстан, Үзбекстан	1	Протестант (Христос)
b.	Мексик, Парагвай	2	Шийт (муслим)
c.	Камбож, Тайланд	3	Үнэн алдартан (Христос)
d.	Украйн, Болгар	4	Будда
e.	Иран, Азербайжан	5	Сүннит (муслим)
f.	Швед, Дани	6	Католик (Христос)

